



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑᠑ оны ᠐᠖ сарын ᠑᠒ өдөр

Дугаар А/᠖᠑᠐

Мандалговь

“Сэтгэшгүй оддын чуулган” аялал
жуулчлалын арга хэмжээний
зардал батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.21, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.8, 16.1.12, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтын 4.2 дахь хэсэгт батлагдсан "Аялал, жуулчлал хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ" ажлын батлагдсан зардлаас “Сэтгэшгүй оддын чуулган” аялал жуулчлалын арга хэмжээний зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө, оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111004

Аймгийн Засаг даргын 2022 оны 06
дугаар сарын 21-ны өдрийн 1/620
дугаар захирамжийн хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Төсөв
1	Соёлын биет бус өвийн арга хэмжээний үзүүлбэрийн зардал	5,000,000
2	Хэвлэл мэдээллийн зардал	5,000,000
	Нийт	10,000,000